



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/05

Бэрх хот

2026 оны цэргийн
бүртгэл явуулах тухай

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, "Батлан хамгаалахын тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, "Цэргийн албаны тухай" хуулийн 34 дүгээр зүйл, Хэнтий аймгийн засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/690 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Э.Мягмарсүрэн (Захирагчийн ажлын албаны дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Соёл-Эрдэнэ (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Гишүүдэд:
Д.Хонгорзул (Улсын бүртгэгч)
Д.Оюунтүлхүүр (Хүүхэд, гэр бүлийн
нийгмийн ажилтан)
М.Түмэндэмбэрэл (Төсөв, төрийн
сангийн мэргэжилтэн)

2. 2026 оны цэргийн бүртгэлийг 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 01 дүгээр сарын 23-ны өдрийг дуустал зохион байгуулсугай.

3. Цэргийн бүртгэлийг чанартай зохион байгуулахыг комиссын гишүүдэд, дүн мэдээг заагдсан хугацаанд хүргүүлэхийг комиссын дарга (Э.Мягмарсүрэн)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ  Ч.ЭНХЖАВХЛАН

232 601010